

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын тэмдэглэл

Оролцсон нь:

Н.Соёмбо - ТУЗ-ийн дарга
М.Алтанцэцэг – ТУЗ-ийн гишүүн
Х.Анар - ТУЗ-ийн гишүүн
Н.Тулга – ТУЗ-ийн гишүүн
Э.Норовринчин – ТУЗ-ийн гишүүн
Н.Хишигсүрэн – ТУЗ-ийн гишүүн
А.Ганцэцэг – НЯ-БО
Г.Даваажаргал- Компанийн ажилтан
Д.Бат-Өлзий – Компанийн ажилтан

Хурлын ирц 67,63 хувь байгааг хурал зохион байгуулах комиссын дарга Х.Анар танилцуулж 2020 оны Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг эхлүүллээ. Хүн хоорондын зай барих халдвар хамгааллын дэглэмийг сайн баримтлан хурлын ажиллагаанд оролцохыг сануулав. Компанийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын даргад компанийн нийт хувьцааны 35544 ширхэг хувьцааг эзэмшигч Н.Соёмбо өөрийн нэрийг хурлын нарийн бичгийн даргад менежер Х.Анарын нэрийг дэвшүүлж хуралд оролцогсдын 100 хувийн саналаар хурлын дарга, хурлын нарийн бичгийн дарга нарыг сонголоо. Мөн хурлын нарийн бичгийн дарга Х.Анар хурлын дэгийг танилцуулав.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн эцсийн тайлангийн талаар ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэх, батлах
2. Аудиторын дүгнэлтийг хэлэлцэх ,
3. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд идэвхтэй оролцох, шаардлагатай болон хүсэлт гаргасан хамтран ажиллах компаниа сонгох , гэрээ байгуулах шаардагдах төсөв төлөвлөгөөг гарган тухай бүрт нь ТУЗ-ийн хурлын шийдвэрээр баталж шийдвэр гаргах ,
4. Харьяа дээд байгууллагаас гаргасан тогтоол шийдвэр , удирдамж , мөрдөгдөж буй хууль дүрэм болон компанийн дүрмээр тогтоосон асуудлын хүрээнд компанийн бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх , хэрэгжүүлэх ,

5. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх санхүүгийн тогтвортой байдлыг хангах , ажлын байр нэмэгдүүлэх, цаашид бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилготойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөх,
6. Компанийн эзэмшлийн газрыг зөв зохистой ашиглах зорилгоор хийгдэх ажлыг бизнес төлөвлөгөө болон судалгааг нарийвчлан гаргаж шаарлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх,
7. Компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлал бүхий 8,08 га хүнсний ногоо тариалах зориулалтын газрыг түрээслэх, зориулалтыг өөрчлөх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор худалдан борлуулах, үндсэн хөрөнгөөс хасах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх,
8. Гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх,

Хурлын явц :

Хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал М.Алтанцэцэг танилцуулав.

Тэрээр бид дэлхийг нөмөрсөн цар тахлын үед , олон ч удаагийн хөл хорионы нөхцөлд өнгөрсөн жилийн үйл ажиллагааг явууллаа. Үйл ажиллагаа явуулж буй ААН , Хувь хүнд түрээсийн орлогын хөнгөлөлт үзүүлээ.

Гэвч хүнсний үйдвэрлэл явуулдаг байгуулагууд олонхи нь байдаг нь давуу тал болсон. Өнгөрсөн онд олон жилээр хуримтлагдсан татваруудыг төлж барагдуулсан. Одоогоор тулгамдсан өр зээл байхгүй байна. Энэ их өр зээлийг төлж барагдуулахад компанид гүн туслалцаа үзүүлсэн ТУЗ-ийн дарга Н.Соёмбо , ТУЗ-ийн гишүүн Н.Тулга нарт талархснаа хэлэх ёстой. Мөн компани “ҮЦТХТ” ХХК-тай үнэт цаас хадгаламжийн болон үнэт цаастай холбоотой гэрээний заалтыг ханган төлбөр тооцоог барагдуулан ажилласан байна. Компанийн өнгөрсөн оны ээлжит хурлын болон ТУЗ-ийн хурлын шийдвэр , холбогдох дээд байгууллагаас баталсан журам , сануулга албан шаардлага зэргийг баримтлан үйл ажиллагаагаа явууллаа. Сард төвлөрүүлдэг түрээсийн орлогыг нэмэгдүүлэх, зарцуулалтанд хяналт тавих чиглэлийг баримтлан ажиллалаа гэв .

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаатай холбоотой АМХЭГ-аас зарлагдсан сонгон шалгаруулалтад оролцож амжаагүйг тэмдэглэв.

Компанийн нягтлан бодогч А.Ганцэцэг 2020 оны санхүү, татварын тайлан хэрхэн тооцогдож гарсан тухай тодорхой танилцууллаа. Тэрээр 2020 онд : Компанийн жилийн санхүүгийн тайлан баланс татваруудын тайлан хугацаандаа гарлаа.

Тайлант хугацаанд компани 97,024,375 төгрөгийн орлого олж /97,872,064 / зарлага гарчээ. Жилийн эцсийн байдлаар /-847690 / төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Төлөгдөх ёстой татварт /НӨАТ -д /10,730,814/ , НДШ /4,560,931/ ХАОАТ / 3,765,153/ , мөн ҮХЭХАТ /927,690/ цаг тухайд нь төлж барагдууллаа. Одоогоор НДШ болон татварт / 6,324,184/ өр байна. Энэ тал дээр өмнө жилүүдээс маш их ахиц гарсан нь сайшаалтай хэрэг гэж бодож байна хэмээн танилцууллаа.

Компанийн 2020 он жилийн эцсийн санхүүгийн тайлан балансаа “Б ЭНД СИ АУДИТ” ХХК-иар баталгаажуулалт хийлгэн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн нийтээр хүлээн зөвшөөрөөгдсөн зарчмын дагуу , бусад хууль тогтоомж дүрэм журмыг үндэслэн үнэн зөв хийж гүйцэтгэсэн байна гэсэн аудиторын дүгнэлт өгсөн байна гэв. ХУД-ийн 12- р хорооны нутаг дэвсгэрт байрлах компанийн эзэмшлийн 10,7 га ногоо тариалах зориулалтын газарт 24,500,000/хорин дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгөөр материал авч хашаа барих ажлыг хийж гүйцэтгэлээ. Хашаа хатгаж олон жил болсон гэсэн айл өрхүүдийн байдлыг харж үзэн хорооны засаг дарга болон иргэдтэй харилцан тохиролцож компанийн газрыг 8,08 га болгон багасгаж кадастрын зургыг шинэчлэн хийлгэж холбогдох байгууллагад хүсэлт гарган өгсөн талаар компанийн менежер Х.Анар ярьж танилцууллаа. Тэрээр энэ газрыг удаан хугацаагаар түрээслэх эсвэл худалдан борлуулах асуудлыг ч хэллээ. Цар тахлын хүнд үеийг даван туулах , ажлын байраа авч үлдэх , улмаар ажлын байр нэмэгдүүлэх , санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бизнес эрхлэхтэй холбоотойгоор их хэмжээний гэрээ хэлцэл хийх , зээл авах шаардлага гарч болох бөгөөд энэ ажлыг хөөцөлдөх хэрэгтэй талаар ТУЗ-ийн дарга Н.Соёмбо ярих.

Мөн компанийн гүйцэтгэх захирал ажлаа хүлээлгэн өгөх талаар хүсэлт гаргасан тухай танилцуулав.

Санал шүүмжлэл :

Н.Соёмбо : Тайлант хугацааны компанийн үйл ажиллагааны болон санхүү татварын тайлан баланс, аудиторын дүгнэлтийг сонсож танилцлаа. Татваруудын үлдэгдэл өрийг төлж барагдуулах , компанийн эзэмшлийн газар дээр хашаа барих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн нь сайшаалтай. Одоо харин компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, компани сар бүр өөрийн орлоготой болох тал дээр анхаарч ажиллах, судалгаа гаргах , төсөл, төсөв төлөвлөх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна. Энэ тал дээр төвлөрч ажиллах хэрэгтэй гэв.

Н.Хишигсүрэн : 2020 оны Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг сонсож ойлголоо. Өнгөрсөн хугацаанд байгуулага байтугай улс үндэстэн эдийн засгийн байдлаараа хүнд байдалд орсон энэ үед удирдлагын ажилласан байдлыг дүгнэхэд ахиц дэвшил гаргасан байна. Одоо бизнес төлөвлөгөө гаргах, түүнээс хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллавал зүгээр гэж санагдаж байна. Хурлаас гарах шийдвэрийг хүндэтгэн үзэж хүлээн авна. Шаардлагатай зүйлд гар бие оролцоно гэв.

Н.Тулга : Өнгөрсөн оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан баланс , аудиторын дүгнэлттэй танилцлаа. ТУЗ-ийн даргатай ярилцаж олон жилийн татварын үлдэгдэл өрийг төлж барагдуулъя. Компани ямар ч гэсэн санхүүгийн хувьд тогтвортой ажиллах боломжтой болно байх. Тэр шаардлагатай үйл ажиллагааг нэвтрүүлж ажиллах боломж бүрдэнэ гэж ойлгож байна. Компанийн удирдлага компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр сайн ажиллах шаардлагатай байна. Энэ чиглэлээр ажиллах явцад дэмжлэг туслалцаа үзүүлэх болно гэв. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүндэтгэн хүлээн авна гэлээ.

Э.Норовринчин : Өнгөрсөн оны тайлангуудыг сонсож танилцлаа. Цар тахал , хөл хорионы хүнд үед орлогоо нэмэгдүүлж , татвар зээлийн өрөө төлж чадсан нь сайшаалтай хэрэг. Түрээслэх талбайгаа өргөжүүлж чадсан байна. Энэ эрчээрээ ажиллаж бизнесийн чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх тал дээр хүн бүр хүчин чармайлт гаргах хэрэгтэй гэж санагдлаа . Бид бүгдээрээ санал санаачлага гарган ажиллах хэрэгтэй юм байна. Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авч боломжоороо тусалж дэмжинэ гэв .

Х.Анар : Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Компани өнгөрсөн онд үндсэн болон бусад үйл ажиллагааны чиглэлээрээ тодорхой үе шаттайгаар төлөвлөгөө гарган ажилласан боловч цар тахлын нөхцөл байдлаас үүдэн зарим ажлууд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж ажил хэрэг болох тал дээр хүндрэлтэй болж ирсэн харагдаж байна. Гэвч компани өөрийн нөөц боломжиндоо тулгуурлан түрээсийн болон бусад үйл ажиллагааг тасалдуулахгүй байх нөхцлийг гүйцэтгэх удирдлага цаг тухай бүрт нь авч тодорхой хөнгөлөлт чөлөөлөлтийг аж ахуй нэгжүүдэд үзүүлж ажиллаж ирсэн нь ажлын байраа авч үлдэх хүсэлтэй аж ахуй нэгж болон түрээслэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг болж өгсөнөөс гадна ковид 19 цар тахалын хүнд нөхцөл байдлын үед компани санхүүгийн хувьд алдагдал багатай давж гарахад томоохон түлхэц болсон гэж харагдаж байна. Иймд цаг үеийн нөхцөл байдал сайжирч эдийн засаг сэргэх үед төсөл, төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлэх ажлуудыг цаг алдалгүй зохион байгуулж ажиллана гэж найдаж байна. Хурлаас гарах шийдвэрийг хүндэтгэн үзэж санал нэгтгэй дэмжих болно гэв.

Н.Соёмбо : Жил бүрийн хурлаар ХУД-ийн газрын талаар ярилцах юм . Тодорхой шийдвэр гарах түвшинд яагаад хүрч чадахгүй байна?

М.Алтанцэцэг : ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлах энэхүү газар дээр юм хийж чадахгүй байна. Нөхцөл бололцоо, санхүүгийн чадавхи хүрэлцэхгүй байна.Ер нь ч хотын хөгжил баруун тийш төвлөрөх болж байгаа. Дээрээс нь газрын эрэлт хэрэгцээ ч ихсэж байна. Иймд энэ газрыг түрээслэх, худалдан борлуулах гарц шийдэл гарах байх гэж найдаж байгаа. Ямар ч гэсэн дүүргийн Газрын Албанаас өгсөн албан шаардлагыг биелүүлж чадсан . Ногоо тарих , хөргүүр хийх , түрээслэх гэсэн хүмүүс ч холбогдож байгаа. Нэг шийдэл гаргаж чадах байх гэж бодогдож байгаа.

Н.Соёмбо : Гүйцэтгэх удирдлагын гаргасан хүсэлтийг энэ удаад хүлээж авч чадахгүй болсон . Цар тахал, хөл хорио , өндөржүүлсэн бэлэн байдлын цаг үетэй удирдлагад ажиллах хүнийг одоогоор олж чадаагүй байгаа. Иймд гүйцэтгэх удирлагыг улируулан ажиллуулах саналтай байна.

Х.Анар : Гүйцэтгэх захирлыг өөрчлөхгүй гэсэн ТУЗ-ийн даргын саналыг дэмжиж байна. Ер нь гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх , эс өөрчлөх тухайд санал хураавал яасан юм бэ? Гэснээр санал хураалт явуулж 83,3 % -ийн саналаар гүйцэтгэх захиралыг хэвээр ажиллуулахаар тохиров.

М.Алтанцэцэг : Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах тал дээр гүйцэтгэх удирдлага хичээнгүйлэн ажиллах болно. Гэхдээ компанийн ТУЗ бидний ажилд туслах хэрэгтэй. Ер нь үйл ажиллагаа өргөжүүлэх төлөвлөгөө, гаргаж хийх

шаардлагатай тохиолдолд ТУЗ-д хандаж шийдвэр гаргуулан хэрэгжүүлж ажиллах болно гэв.

Ганцэцэг: Ковид 19 цар тахал болон эдийн засгийн тогтворгүй байдал мөнгөний ханшийн уналт зэрэг нь манай санхүүгийн нөхцөл байдалд хүндээр тусаж байна. Иймд өөрсдийн нөөц бололцоог ашиглан тодорхой ажлуудыг дэс дараатайгаар төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллаж чадвал дээрхи эрсдлээс гарах боломж бий гэж үзэж байна. Энэ удаагийн хувь нийлүүлэгчдийн хурлаас тодорхой шийдэл, санал санаачлага гарах байх гэж найдаж байна. Хурлаас гарах шийдвэрийг дэмжиж ажиллах болно.

Гэснээр санал шүүмжлэлийг тасаллаа.

Шийдвэрлэсэн нь :

1. 2020 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайланг зөвшөөрөхөөр тогтоох,
2. Аудиторын дүгнэлтийг зөвшөөрөхөөр,
3. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд идэвхтэй оролцох нөхцлийг бүрдүүлэхээр,
4. Хамтран ажиллах хүсэлт гаргасан компанийг дэмжин гэрээ хийхээр,
5. Харьяа дээд байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийн хүрээнд компанийн дүрмээр тогтоосон зүйл заалтыг үндэслэн компанийн бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр,
6. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ажлын байр нэмэгдүүлэх, цаашид бизнес төлөвлөгөөг, хэрэгжүүлэх зорилготойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгохоор,
7. Компанийн эзэмшлийн СХД болон ХУД-дэхь газрыг зөв зохистой ашиглах зорилгоор хийгдэх ажлуудын бизнес төлөвлөгөөг боловсруулах, холбогдох тооцоо судалгааг гаргаж шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлыг хуралдуулж шийдвэрлүүлэхээр,
8. Компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлал бүхий 8,08 га газрын зориулалтыг өөрчлөх, үйл ажиллагааны болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор түрээслэх, худалдан борлуулах, үндсэн хөрөнгөнөөс хасах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр,
9. Компанийн гүйцэтгэх захирлыг улируулан ажиллуулахаар холбогдох тогтоол шийдвэрүүдийг гаргахаар тус тус шийдвэрлэв.

Хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14 цаг 25 минутад өндөрлүүлэв.

Тэмдэглэл хөтөлсөн М.Алтанцэцэг /



Танилцсан :

ТУЗ-ийн дарга / Н.Соомбо /
ТУЗ-ийн гишүүн / М.Алтанцэцэг /
ТУЗ-ийн гишүүн / Н.Тулга /
ТУЗ-ийн гишүүн / Х.Анар /
ТУЗ-ийн гишүүн / Э.Норовринчин /
ТУЗ-ийн гишүүн / Н.Хишигсүрэн /
Компанийн ня бо / А.Ганцэцэг /
Компанийн ажилтан / Г.Даваажаргал /